

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлгэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан

Аудитын код: ГАА-2026/004/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2026 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: <a href="mailto:tserenkhandd@audit.gov.mn">tserenkhandd@audit.gov.mn</a> Ахлах аудитор: М.Атарцэцэг Утас: 88984411 Цахим хаяг: <a href="mailto:atartsetseg.m@audit.gov.mn">atartsetseg.m@audit.gov.mn</a>
--	---



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091  
Утас: (976) 70 48 34 13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 03. 05 № 145

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дэлгэр сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварын орлого 36.5 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 2.4 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 2.4 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1.0 сая төгрөгөөр, бууны албан татварын орлого 0.1 сая төгрөгөөр тус тус тасарсан,
- Малын тоо толгойн албан татварын орлого 0.5 сая төгрөгийг сумын Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлээгүй,
- Төрийн хэмнэлтийн хууль зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2.4 сая төгрөгийн гарын бэлэг худалдан авч малчдад тараасан,
- Сумын орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт 2.7 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон,

822511000431

- Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн харьяа нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 109.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 27 дугаар зүйлийн 27.1.7, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам", Дэлгэр сумын Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 29 дүгээр тогтоолын заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Сумын орон нутгийн төсвийн орлогыг 578.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 579.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 1.0 сая төгрөг буюу 0.2 хувиар давуулан биелүүлжээ.

### **Аудитын гол асуудал**

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Тайлант оны өр төлбөрийн үлдэгдэл 55.2 сая төгрөгийн 80.6 хувь буюу 47.9 төгрөг нь төсвийн байгууллагын ХХОАТ, тээвэр шатахууны өр төлбөр байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 1 хөтөлбөр, 5 зорилт, 36 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 94.6 хувьтай үнэлжээ.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	706,378.0	911,916.6
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	269,393.6	471,704.2
3	АВЛАГА	300,791.3	249,539.3
4	БАРАА МАТЕРИАЛ	88,193.1	88,193.1
5	НӨӨЦИЙН БАРАА	37,500.0	88,550.0
6	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10,500.0	13,930.0
7	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,028,516.4	5,264,959.2
8	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,028,516.4	5,264,959.2
9	Биет хөрөнгө	3,481,869.8	3,718,312.6
10	Биет бус хөрөнгө	1,546,646.6	1,546,646.6
11	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,734,894.5	6,176,875.7
12	НИЙТ ӨР ТӨЛБӨР	174,910.3	51,867.1
13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	174,910.3	51,867.1
14	Өглөг	174,910.3	51,867.1
15	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,559,984.2	6,125,008.7
16	Засгийн газрын хувь оролцоо	5,559,984.2	6,125,008.7
17	Засгийн газрын оруулсан капитал	634,038.9	634,038.9
18	Хуримтлагдсан үр дүн	4,396,540.0	4,961,564.5
19	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	529,405.3	529,405.3
20	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,734,894.5	6,176,875.7

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөг)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,444,016.8	2,837,048.2
2	ТАТВАРЫН ОРЛОГО	454,086.5	564,163.2
3	Орлогын албан татвар	383,931.2	488,540.9
4	Хувь хүний орлогын албан татвар	422,582.7	518,865.6
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(38,651.5)	(30,324.7)
6	Хөрөнгийн албан татвар	34,550.2	49,040.3
7	Бусад татвар, төлбөр, хураамж	35,605.2	26,582.0
8	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	378,384.4	2,272,885.0
9	Тусламжийн орлого	0.0	1,403,939.0
10	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,611,545.9	0.0
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,986,580.7	2,032,507.0
12	УРСГАЛ ЗАРДАЛ	1,986,580.7	2,032,507.0
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,942,441.0	2,012,601.1
14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	683,092.2	812,462.7
15	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,051.1	104,219.1
16	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	667,644.6	665,299.6

**Дэлгэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан**

17	Хангамж, бараа материалын зардал	110,168.6	47,892.1
18	Нормативт зардал	1,000.0	1,832.8
19	Эд хогшил, урсгал засварын зардал	18,598.4	24,746.9
20	Томилолт, зочны зардал	5,294.2	6,190.0
21	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,109.0	22,432.8
22	Бараа үйлчилгээний бусад зардал	324,482.9	327,525.2
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,139.7	19,905.9
24	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	457,436.1	804,541.2
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	355,491.9	250,977.2
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(355,491.9)	(250,977.2)
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	101,944.2	553,564.0

**2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөг)**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	5,462,237.6	5,462,237.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(4,197.6)	(4,197.6)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,458,040.0	5,458,040.0
4	Тайлант үеийн үр дүн	101,944.2	101,944.2
5	2024 оны 12-р сарын 31- нээрх үлдэгдэл	5,559,984.2	5,559,984.2
6	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,559,984.2	5,559,984.2
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	11,460.5	11,460.5
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,571,444.7	5,571,444.7
9	Тайлант үеийн үр дүн	553,564.0	553,564.0
10	2025 оны оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,125,008.7	6,125,008.7

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөг)**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,170,321.6	2,463,522.2
2	ТАТВАРЫН ОРЛОГО	454,086.5	564,163.2
3	Орлогын албан татвар	383,931.2	488,540.9
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(38,651.5)	(30,324.7)
5	Хөрөнгийн албан татвар	34,550.2	49,040.3
6	Бусад татвар, төлбөр, хураамж	35,605.2	26,582.0
7	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,522.8	3,466.5

**Дэлгэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй аудитын тайлан**

8	Газрын төлбөр	28,880.9	22,843.1
9	Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,201.5	272.4
10	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	104,689.3	1,899,359.0
11	Нийтлэг татварын бус орлого	104,689.3	154,597.2
12	Тусламжийн орлого	0.0	1,403,939.0
13	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	340,822.9
14	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,611,545.9	-
15	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,586,665.3	1,891,070.5
16	УРСГАЛ ЗАРДАЛ	1,586,665.3	1,891,070.5
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,542,525.6	1,871,164.6
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	646,937.4	844,835.8
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,771.2	122,379.8
20	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	599,599.4	733,721.8
21	Хангамж, бараа материалын зардал	48,152.0	42,835.4
22	Нормативт зардал	1,000.0	1,832.8
23	Эд хогшил, урсгал засварын зардал	18,221.5	68,480.9
24	Томилолт, зочны зардал	5,294.2	6,190.0
25	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,086.1	37,273.3
26	Бараа үйлчилгээний бусад зардал	121,463.8	13,614.8
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,139.7	19,905.9
28	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	583,656.3	572,451.8
29	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	547,580.0	369,991.2
30	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	547,580.0	369,991.2
31	Дотоод эх үүсвэрээр	547,580.0	369,991.2
32	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-547,580.0	-369,991.2
33	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	69,000.0	150.0
34	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(69,000.0)	(150.0)
35	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(32,923.7)	202,310.6
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	302,317.3	269,393.6
37	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	269,393.6	471,704.2

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,538,614.8	2,424,256.3	114,358.5	95.5
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	177,000.0	-	177,000.0	-
11	Татварын орлого	566,901.7	564,163.2	2,738.5	99.5
110	Орлогын албан татвар	471,760.8	488,540.9	(16,780.1)	103.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	502,085.5	518,865.5	(16,780.0)	103.3

**Дэлгэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
хураангуй аудитын тайлан**

110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	400,793.7	407,103.2	(6,309.5)	101.6
110002	Үйл ажиллагааны орлого	8,242.6	10,612.4	(2,369.8)	128.8
110003	Хөрөнгийн орлого	37,025.8	43,133.0	(6,107.2)	116.5
110004	Хөрөнгө борлуулсны орлого	3,000.2	576.0	2,424.2	19.2
110008	Шууд бус орлого	53,023.2	57,440.9	(4,417.7)	108.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(30,324.7)	(30,324.7)	(0.0)	100.0
110101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(30,324.7)	(30,324.7)	(0.0)	100.0
113	Хөрөнгийн албан татвар	78,204.6	49,040.3	29,164.3	62.7
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	4,338.9	11,763.4	(7,424.5)	271.1
113002	Бууны албан татвар	1,890.0	1,770.0	120.0	93.7
113004	Малд ногдуулах албан татвар	71,975.7	35,507.0	36,468.7	49.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	16,936.3	26,582.0	(9,645.7)	157.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,230.3	3,466.4	(1,236.1)	155.4
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2,230.3	1,175.3	1,055.0	52.7
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	-	1,256.0	(1,256.0)	
118011	Бусад татвар	-	1,035.1	(1,035.1)	
1181	Газрын төлбөр	12,000.0	22,843.1	(10,843.1)	190.4
118101	Газрын төлбөр	12,000.0	22,843.1	(10,843.1)	190.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,706.0	272.4	2,433.6	10.1
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2,706.0	272.4	2,433.6	10.1
12	Татварын бус орлого	1,794,713.1	1,860,093.1	(65,380.0)	103.6
120	Нийтлэг татварын бус орлого	81,837.0	150,659.7	(68,822.7)	184.1
120003	Торгуулийн орлого	11,837.0	15,645.4	(3,808.4)	132.2
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	-	59,762.8	(59,762.8)	
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	70,000.0	75,251.5	(5,251.5)	107.5
122	Тусламжийн орлого	1,368,610.6	1,368,610.6	-	100.0
122003	Аймаг нийслэлээс авсан татаас	1,368,610.6	1,368,610.6	-	100.0
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	344,265.5	340,822.8	3,442.7	99.0
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	344,265.5	340,822.8	3,442.7	99.0
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,538,614.8	2,216,129.8	322,485.0	87.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,960,373.6	1,845,988.6	114,385.0	94.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,939,392.6	1,826,082.7	113,309.9	94.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	883,750.1	844,835.8	38,914.3	95.6
210101	Үндсэн цалин	806,207.0	591,362.5	214,844.5	73.4
210102	Нэмэгдэл	77,543.1	231,989.5	(154,446.4)	299.2
210104	Урамшуулал	-	21,483.8	(21,483.8)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,136.3	122,379.8	30,756.5	79.9
210201	Тэтгэврийн даатгал	117,184.1	86,427.6	30,756.5	73.8
210202	Тэтгэмжийн даатгал	8,988.1	8,988.1	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,494.0	4,494.0	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,494.0	4,494.0	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	17,976.1	17,976.1	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	748,447.2	726,763.8	21,683.4	97.1
210301	Гэрэл, цахилгаан	33,000.0	28,808.9	4,191.1	87.3
210302	Түлш, халаалт	713,886.0	696,954.9	16,931.1	97.6
210303	Цэвэр, бохир ус	1,561.2	1,000.0	561.2	64.1
2104	Хангамж, бараа материалын зардал	41,889.0	33,796.1	8,093.0	80.7
210401	Бичиг хэрэг	4,600.0	3,658.7	941.3	79.5
210402	Тээвэр, шатахуун	32,279.0	26,376.4	5,902.6	81.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,160.0	1,936.2	223.8	89.6
210404	Ном, хэвлэл	450.0	299.0	151.0	66.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,400.0	1,525.7	874.3	63.6
2105	Нормативт зардал	2,000.0	1,832.8	167.2	91.6
210502	Хоол, хунс	2,000.0	1,832.8	167.2	91.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76,720.0	68,480.9	8,239.1	89.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	39,600.0	33,009.0	6,591.0	83.4
210604	Урсгал засвар	37,120.0	35,471.9	1,648.1	95.6
2107	Томиллолт, зочны зардал	6,690.0	6,190.0	500.0	92.5
210702	Дотоод албан томиллолт	6,690.0	6,190.0	500.0	92.5

**Дэлгэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
хураангуй аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,810.0	8,188.8	2,621.2	75.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,700.0	7,635.5	64.5	99.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	920.0	-	920.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	350.0	113.3	236.8	32.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	240.0	-	240.0	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100.0	-	100.0	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500.0	440.0	60.0	88.0
210807	Газрын төлбөр	1,000.0	-	1,000.0	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,950.0	13,614.8	2,335.2	85.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,900.0	12,466.1	1,433.9	89.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,050.0	1,148.7	901.3	56.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,981.0	19,905.9	1,075.2	94.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,981.0	19,905.9	1,075.2	94.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,981.0	18,947.9	33.2	99.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000.0	958.0	1,042.0	47.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	508,241.2	369,991.2	138,250.0	72.8
223001	Бусад хөрөнгө	508,241.2	369,991.2	138,250.0	72.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	70,000.0	150.0	69,850.0	0.2
230001	Эргэж төлөгдөх зээл	70,000.0	150.0	69,850.0	0.2
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	1,855,349.3	208,126.5	1,647,222.8	11.2
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(208,126.5)	(1,647,222.8)	11.2
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(208,126.5)	(1,647,222.8)	11.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	250,973.0	(250,973.0)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	459,099.5	(459,099.5)	

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөг)**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>45,328.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>45,328.4</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>45,081.9</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>6,958.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,958.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,039.4</b>
210402	Тээвэр, шатахуун	8,889.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	150.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>29,084.5</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,084.5
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>246.5</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>246.5</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	246.5
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>45,328.4</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>45,328.4</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	45,328.4

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Дэлгэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 3 тусгай сан, 5 байгууллагын (Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв) тогтмол зардал нэгтгэсэн байна.

Аудитаар ЗДТГ-ын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн ба сумын ИТХ, ХХС, БХНСС, ОНХС, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлыг аудитын түүвэрт хамруулсан.

### 3.1 Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил:

Аудитаар 2.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 9.8 сая төгрөгийн 2 зөвлөмж, 19.9 сая төгрөгийн зөрчилд ЗДТГ-ын даргад хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн.

### 3.2.Түүвэрт хамрагдсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хоршоо хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах нөхөн сэргээх сан, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил:

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналыг 376.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан 6 алдааг залруулж, 12.2 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 22.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 42.7 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

### 3.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

- ✓ Аудитаар нийт 21.8 сая төгрөгийн 1 алдаа илрүүлснийг аудитын явцад залруулсан байна. Залруулсан алдаа:

#### Мэдээллийг орхигдуулсантай холбоотой:

- Шилэн дансны цахим хуудсанд санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, 21.8 сая төгрөгийн 13 шийдвэрийг мэдээлээгүйг нөхөн байршууллаа.

Залруулагдаагүй нийт 48.1 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинөөс их бөгөөд харьяа байгууллагуудын материаллаг зөрчил 109.7 сая төгрөг байгаа тул шинж чанарыг харгалзан үзэж "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 48.1 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс, 0.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 47.6 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмжийг хүргүүлсэн.

#### 3.3.1 Төлбөрийн акт

Нэг. Малын тоо толгойн албан татварын орлого 0.5 сая төгрөгийг ОНХС-д төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "Малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна"-д заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу төвлөрүүлсэн 0.5 сая төгрөгийг Дэлгэр сумын Төрийн сан дахь Га.Тонхил ОНХС 100050652400 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт хүргүүлсэн.

### 3.3.2 Албан шаардлага

Нэг. Төсвийн төвлөрүүлэн захирагчид нэгтгэгддэг нэгж байгууллагуудад залруулагдаагүй 109.7 сая төгрөгийн 12 зөрчил илэрч 15.0 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 22.2 сая төгрөгийн 4 зөрчилд зөрчил арилгах албан шаардлага, 52.6 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж, 19.9 сая төгрөгийн 1 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-т "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

### 3.3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### ***Нэг. Батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал***

Илрүүлэлт: Төрийн хэмнэлтийн хууль зөрчиж Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2.4 сая төгрөгийн гарын бэлэг худалдан авч малчдад тараасан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх.

#### **Хоёр. Санхүүжилтийн талаар:**

Илрүүлэлт: Сумын орон нутгийн төсвөөс Засаг даргын Тамгын газарт 2.7 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох"; 14.2.5-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах"; 41 дүгээр зүйлийн 41.1-т "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.5-т "энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;" Дэлгэр сумын Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 29 дүгээр тогтоол"-той нийцэхгүй, хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн хуваарийн дагуу нэгж байгууллагуудад санхүүжилтийг олгож байх.

**Гурав. Орон нутгийн төсвийн орлогын талаар:**

Илрүүлэлт: Хөрөнгө борлуулсны орлого 2.4 сая төгрөгөөр, бууны албан татварын орлого 0.1 сая төгрөг, малын тоо толгойн албан татварын орлого 36.5 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1.0 сая төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 2.4 сая төгрөгөөр тус тус тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Дэлгэр сумын Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 29 дүгээр тогтоолыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлийн нэгтгэл:

(мянган төгрөг)

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Тоо	Дүн
									Тоо	Дүн		
Дэлгэр сумын ТТЗ	1	21.8	1	21.8	-	-	1	21.8	-	-	-	-
Дэлгэр сумын ЗДТГ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дэлгэр сумын ИТХ	1	940.1	-	-	1	940.1	1	940.1	-	-	-	-
Дэлгэр сумын ОНХС	4	363,661.2	1	325,320.7	3	38,340.5	4	363,661.2	-	-	-	-
Дэлгэр сумын БХНС	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дэлгэр сумын ХХС	1	11,564.8	1	11,564.8	-	-	1	11,564.8	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>376,187.9</b>	<b>3</b>	<b>336,907.3</b>	<b>4</b>	<b>39,280.6</b>	<b>7</b>	<b>376,187.9</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Байгууллагын нэр	Бүтэц	Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс	Түвшэрт	Үүнээс											
							Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дэлгэр сумын ТТЗ	1		1	48,147.7	1	482.3	1	-	3	47,665.4	-	-	-	-				
Дэлгэр сумын ЗДТГ	1		1	32,564.0	1	2,830.0	-	-	2	9,825.0	1	19,909.0	-	-				
Дэлгэр сумын ИТХ	1		1	2,540.0	2	2,540.0	-	-	-	-	-	-	-	-				



**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Санал дүгнэлт гаргасан	Түвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Өөрчлөлтгүй	Хязгаралтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ		1				1		
	<b>НИЙТ</b>		<b>1</b>				<b>1</b>		

